



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2005 оны 4 сарын 6 өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

**"Халаалтын зуухны ашиглалт,
зохицуулалтын газар, нийслэлийн өмчит
үйлдвэрийн газрын дүрмийг батлах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 1,3 дугаар заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалтын 2 дахь хэсэг, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа "Халаалтын зуухны ашиглалтын газар" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг "Халаалтын зуухны ашиглалт, зохицуулалтын газар" нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсантай холбогдуулан дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг "Халаалтын зуухны ашиглалт, зохицуулалтын газар" НӨҮГ /Н.Ганболд/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2001 оны 38 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
ВЭГТӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ**

М.ЭНХБОЛД



101
Нийслэлийн Засаг даргын 2005 оны
4 дугаар сарын 5-ны өдрийн 129
дугаар захирамжийн хавсралт

“ХАЛААЛТЫН ЗУУХНЫ АШИГЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР” ИНӨҮГ-ЫН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа Халаалтын Зуухны Ашиглалт, Зохицуулалтын Газар нь / Цаашид газар гэнэ/ Нийслэлийн өмчид үндэслэн төвийн дулааны шугам сүлжээнд холбогдоогүй хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах үүрэг бүхий нийслэлийн өмчит үйлдвэрийн газар байна.

1.2. Газрын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нөхөрлөл компанийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.4. Газар нь тогтоогдсон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банканд харилцах данстай байна.

1.5. Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 13, утас № 342059.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт.

2.1. Газрын даргыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

2.2. Газрын орлогч даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга томилж, чөлөөлнө.

2.3. Газар нь Улаанбаатар хотын Захирагч, түүний ажлын албаны удирдлага дор үйл ажиллагаа явуулж, ажлаа тайлагнана.

2.4 Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч баталж, бүтэц, орон тооны хязгаарт Улаанбаатар хотын Ерөнхий менежер хяналт тавина.

2.5. Газрын дарга нь байгууллагын удирдлага зохион байгуулалтын бүтэц, дотоод журам, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 22 дугаар захирамжаар батлагдсан орон тоо, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

2.6. Газрын зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх, зөвшилцөх үүрэг бүхий даргын зовлолийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга тушаалаар батална. Зөвлөлийн гишүүд гагцхүү зөвлөх үүрэгтэй.

2.7. Газрын даргын эрх, үүрэг, харлуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын даргатай байгуулах гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг Өмчийн Харилцааны Газар, үйл ажиллагааны чиглэлээр Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй гэрээ байгуулан ажиллана.

Гурав. Газрын үүрэг.

3.1. Халаалтын Зуухны Ашиглалт, Зохицуулалтын Газар нь Нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй Нийслэлийн өмчит халаалтын зуухнуудын ашиглалт, засварын ажлыг шууд хариуцан зохион байгуулна.

3.2. Хувийн хэвшлийн халаалтын зуухны техник технологийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, үйлдвэрлэлийн мэдээг 14 хоногоор нэггэн авч, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлж байх зэрэг диспетчерийн зохицуулалтын үүрэг гүйцэтгэнэ.

3.3. Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс иргэн, аж ахуйн нэгжид халаалтын зуух барих, ажиллуулах тусгай зөвшөөрөл шинээр олгоход техникийн нөхцөлөө хэрхэн хангасан тухайд дүгнэлт гарган өгөх үүрэг гүйцэтгэнэ.

3.4. Халаалтын зуухны ажилтнуудыг сургах сургалтын төв ажиллуулна.

3.5. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй халаалтын зуухны ажиллагаанд хяналт тавихын тулд ус, нүүрс, үнс, утааны хийн найрлага тогтоох зорилгоор лаборатори ажиллуулна.

3.6. Нийслэл хотын барилга байгууламжуудыг аль болох төвлөрсөн дулааны шугаманд холбох, халаалтын зуухны тоог цөөлөх, зохимжтой хэмжээнд барьж байх, техник технологийн өөрчлөлтийн бодлогыг нэгтгэн зангидах үүрэгтэй байна.

3.7. Халаалтын зуухны ашиглалт, зохицуулалтын газрын харъяа, хувийн хэвшлийн зуухнуудыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, угаа тортоггүй, эдийн засгийн хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөнгөлттэй зээл олгуулах, тоног төхөөрөмж лизингээр ашиглуулах, зуухны шинэчлэлтийн төсөлд хамруулах ажлыг хариуцан зохион байгуулна.

3.8. Төвлөрсөн дулааны шугаманд холбогдоогүй, халаалтын зуухнаас дулааны эх үүсвэр авдаг төсвийн байгууллагууд /сургууль, цэцэрлэг, эмнэлэг г.м / -ын дулааны шугам, сантехникийн засвар үйлчилгээг хэрэглэгчийн тухайн жилийн батлагдсан төсвийн зардалд багтаан хийж гүйцэтгэнэ.

3.9. Хувийн хэвшлийн халаалтын зуухнуудад аваар, зогсолт, саатал гарсан үед хариуцагчийн хүсэлтийн дагуу техник, хүн хүчний туслалцаа үзүүлж, иргэд, аж ахуйн нэгжийн хөвийн ажиллаж амьдрах нөхцөлийн хангахад туслана.

3.10. Техник технологийн шинэчлэлт хийгдсэн зуухнуудад ажиллагааны хугацаанд нь жилд 1-ээс доошгүй удаа мэргэжлийн үзлэг хийж, гарсан дүгнэлтээ холбогдох байгууллага, албан тушаалтанд асуудал болгон дэвшүүлж шийдвэрлүүлнэ.

3.11. Хэрэглэгчдийг чанартай, найдвартай ажил үйлчилгээгээр хангаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлыг бууруулж, өндөр үр ашгийн төлөө ажиллана.

3.12. Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, ажиллагсдын эрүүл ахуй, техникийн аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгнө.

3.13. Боловсон хүчний бодлого боловсруулж, өөрийн нэгжүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, удирдах болон мэргэжлийн ажиллагсдыг мэдлэг боловсролоо дээшлүүлэх бололцоогоор хангана.

3.14. Хөдөлмөрийн харилцааг хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон иргэний хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн зохицуулна.

Дөрөв. Газрын эрх

4.1. Газрын байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр гарч Монгол Улсын Аж Ахуйн нэгжийн тухай хуулинд заасан журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

4.2. Газар нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгийн болон эд хөрөнгий бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн шүүх арбитрайн байгууллагад нэхэмжлэгчээр орно.

4.3. Газар нь өөрийн салбар нэгж байгуулан ажиллуулж болно.

4.4. Газар нь үйлчилгээний үнийн саналаа Нийслэлийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөлд оруулан, шийдвэрлүүлнэ.

4.5. Ашиглалт, засварын ажилд шаардагдах түүхий эд, материал, тоног төхөөрмжийг хуулийн хүрээнд гадаад, дотоодын зах зээлээс бие даан бэлтгэнэ.

4.6. Ажил үйлчилгээ үзүүлсэний үр дүнд олсон орлогыг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

Тав. Газрын санхүү бүртгэл, хяналт.

5.1. Газрын эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тайланг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

5.2. Газрын санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь газар байгуулагдсан өдрөөс эхлэж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь газрыг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

5.3. Газар нь Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.4. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.5. Газар нь Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.6. Газрын Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль, тогтоомжинд заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.7. Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримтаар хангана.

5.8. Газрын санхүүгийн тооцоо тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

5.9. Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх ашиглуулах, болон худалдах, хувьчлахдаа төрийн болон орон хутгийн өмчийн тухай хуульд заасан журмыг баримтлана.

5.10. Халаалтын Зуухны Ашиглалт, Зохицуулалтын Газар нь өөрийн хариуцсан зуухны борлуулалтын орлого, хувийн хэвшлийн халаалтын зууханд техникийн нөхцөлийн дүгнэлт гаргах, түвшин тогтоох үзлэг явуулах, сургалт зохион байгуулах, шинжилгээ хийх, техник хүн хүчний туслалцаа үзүүлсэний орлого зэргээс санхүүжнэ.

Зургаа. Үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах.

6.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь газрыг үүсгэн байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

6.2. Халаалтын Зуухны Ашиглалт, Зохицуулалтын Газрыг татан буулгах тохиолдолд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон комисс уг ажлыг эрхэлнэ.

6.3. Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан тэнцэл гаргуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, нийтэд мэдээлж, өр төлбөрийг хуульд заасан дараалал журмын дагуу төлсөний дараа үлдсэн хөрөнгийг 3 сарын дотор Нийслэлийн Өмчийн Харилцааны Газарт шилүүүлнэ.

Долоо. Хариуцлага.

7.1. Газрын албан тушаалтан нь байгууллагын дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхолын төлөө шударгаар ажиллана.

7.2. Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамж, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.3. Газрын дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж, байгууллагадаа хохирол учруулсан бол өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүхэн хариуцна.

Найм. Бусад.

8.1. Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2. Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын Газарт мэдэгдэж бүртгүүлнэ.